

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2024 оны 12 дугаар сарын 18						Улаанбаатар хот	
Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хувь
1	2	3	4	5	6	7	8
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл							
Салбарын үр дүн: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, хотын хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэглээг дотоодоос хангана.							
НХТЖҮЧ 4.5.1 НЗДҮАХ-3.3.3.2. Алтан намар арга хэмжээний хүрээнд эх орны хөрсөнд ургасан төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдааг зохион байгуулна;							
1	Төмс, хүнсний ногооны борлуулалт	тонн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	7800	8000	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн “Төмс хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулах тухай” А/133 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн 4 дүгээр хороо, Барилгачдын талбай, 2 дугаар хороо, Бөмбөгөр худалдааны төвийн гадна талбайд гарал үүслийн бичиг, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичгийг үндэслэн Сэлэнгэ, Дархан-Уул, Өмнөговь, Ховд аймгийн 35 ногоочин иргэдийг хамруулан төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа "Алтан намар-2024" арга хэмжээг зохион байгуулж, нийт 77.5 тонн хүнсний ногоо худалдан борлуулж,	100

						300,722,000 төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан.	
НХТЖҮЧ-4.5.2 НЗДҮАХ-3.3.2.6 Нийслэлд мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд орж ирсэн малыг гаргаж, мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;							
2	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хувь	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	90	100	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны А/07, дүүргийн Засаг даргын 2024 оны А/03 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр, хориглосон бүсэд мал, амьтан орж ирснээр малын халдварт болон гоц халдварт өвчин дамжин тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, орж ирсэн малыг зөвшөөрсөн бүс нутагт гаргах, эздийг олж тогтоон, хүлээлгэн өгөх, зөрчлийг тухай бүр арилгах зорилгоор 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд 7 хоногийн 2 өдөр 7-24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт хяналт тавьж, нийт 1096 литр шатахуун зарцуулан, 3451 тооны адуу малыг дүүргийн нутаг дэвсгэрээс гарган ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/410 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2024 оны А/127 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй гэрийн тэжээвэр амьтдыг халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, туулгалт, боловсруулалт хийх ажлыг дүүргийн мал эмнэлгийн газар болох “Содхан” ХХК-тай хамтран 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж нийт 3599 нохой, муурыг вакцинд хамруулан, 7198 мл вакцин зарцуулсан.	100
ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							

Салбарын үр дүн: Агаар дахь тоосонцрын агууламжийг 25 хувиар бууруулна.							
ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ							
АХ-2.5.5, НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.2 Бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулах;							
3	Бичил цэцэрлэгт хүрээлэн	Тоо	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	36	70	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 84 бичил цэцэрлэгт хүрээлэн байгаа бөгөөд арчилгаа хамгаалалтыг дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэн ажиллаж байна. 2024 онд Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 3, 6, 18, 20, 22 дугаар хороодод шинээр 3 тоглоомын талбай, дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр сэргээн засаж сайжруулсан 2 бичил цэцэрлэг хүрээлэн, нийт 5 тоглоомын талбай, бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулсан.	100
АХ-2.5.5, НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.2 3*3 сагсан бөмбөгийн талбай шинээр байгуулах;							
4	Байршил	Тоо	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	34	20	Дүүргийн хэмжээнд гэр хорооллын болон орон сууц, нийтийн эзэмшлийн гудамж талбайд стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын талбай 39 байгаагаас 2024 оны үйл ажиллагааны хүрээнд шинээр 15, 16, 20 дугаар хороодод тус бүр 1 талбай, 22 дугаар хороонд 2 талбай, нийт 5 тоглоомын талбайг шинээр байгуулан ажилласан.	100
АХ-2.5.5, НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.2 "Шарилжгүй Улаанбаатар" аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;							
						Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас уламжлал болгон зарладаг “Шарилжгүй Улаанбаатар” аяныг нийслэлийн хэмжээнд хоёр үе шаттайгаар зохион байгуулан ажилласан. Дүүргийн хэмжээнд 2024 оны 06, 08 дугаар саруудад хоёр үе шаттайгаар хөл газрын ургамлын тоосноос үүдэх харшлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийн тоог бууруулах, хөл газрын ургамлыг тайрах, хадах, зэрэг ажлыг нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, далан суваг, гуу жалга	

5	Цэвэрлэсэн талбайн хэмжээ	м2	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	1,800,000	2,100,000	дагуух шарилж луулийг цэвэрлэн ажилласан. Дээрх цэвэрлэгээний ажилд дүүргийн 1-24 дүгээр хороодын Засаг даргын ажлын алба, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, тээвэрлэгч байгууллагууд оролцож нийт давхардсан тоогоор 3118 гаруй хүн цэвэрлэгээний ажилд хамрагдан 721328м2 талбайг цэвэрлэн, нийт 197 рейсээр 506.5 тонн шарилж луулийг 3 техник хэрэгслээр тээвэрлэн ажилласан. Мөн дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс хороо тус бүр 10 хүний бүрэлдэхүүнтэй буюу нийт 240 иргэнийг түр ажлын байраар ханган ажилласан. Дүүргийн 1-24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт хөл газрын ургамлын тоосноос үүдэх харшлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчлөлийн тоог бууруулах, хөл газрын ургамлыг тайрах, хадах, шаардлагатай зориулалтын төхөөрөмжийг 2024 оны 06 дугаар сард хороо тус бүрд буюу төвийн бүс буюу 1-6 дугаар хороодод тус бүр 1 ширхэг, гэр хорооллын 7-24 дүгээр хороодод тус бүр 2 ширхэг, нийт 42 ширхгийг дүүргээс олгосон.	100
АХ-2.5.5, НХТЖҮЧ-6.4.1, НЗДҮАХ-5.1.1 Мод, бут тарьсан иргэдийг урамшуулах;							
6	Урамшуулал олгосон айл, өрх	Тоо	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	100	200	Өөрийн хөрөнгөөр тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах зорилгоор “Манай хороо-Миний гудамж” аяны хүрээнд аж ахуй нэгж, байгууллага болон иргэдийг шагнаж урамшуулахаар төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар 1-24 дүгээр хороодын аж ахуй нэгж, байгууллагуудаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн явж тохижилтын ажлыг эрчимжүүлэхээр шаардлага хүргүүлэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад гадна орчноо тохижуулах дүүргийн менежерийн удирдамжийг хүргэн ажилласан. Бүх	100

						нийтээр мод тарих Үндэсний өдөр, “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2700 мод хуваарилсныг хороодоор дамжуулан иргэдэд түгээж, тарилт арчлалт дээр зөвлөгөө өгч хяналт тавин ажиллаж байна. “НОГООН ХОТ-ИРГЭНИЙ ОРОЛЦОО, өрх бүр хашаандаа мод тарья” сургалт хэлэлцүүлгийн хүрээнд дүүргийн 7-24 дүгээр хороодын айл өрхийн төлөөлөл 100 иргэнийг сургалтад хамруулан агч мод 500 ширхэг, шар хуайс 500 ширхэг, улиас 500 ширхэг, нийт 1500 ширхэг 3 нас бүхий модыг тараан өгч сургалтаас авсан мэдлэг мэдээллийн дагуу тарьж суулган ургуулах талаар арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.	
АХ-2.5.10, НХТЖҮЧ-6.2.3, НЗДҮАХ-5.2.7 Нийтийн эзэмшлийн зам талбайд байрших хогийн савны тоог нэмэгдүүлэх;							
7	Нэмэгдүүлсэн хогийн сав	Тоо	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	-	500	“Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК нь хог тээвэрлэлтийг шөнийн цагийн хуваарьт шилжүүлэн төвийн бүсийн 1-6 дугаар хороодын нийт 103 байршлын аж ахуй нэгж, байгууллагын орон сууцны хорооллын дундах хог хаягдлыг оройны 20:00 цагаас өглөөний 05:00 цагийн хооронд тээвэрлэхээр нэмэлт хуваарь гарган ажиллаж байна. Мөн дүүргийн 1 дүгээр хорооны 1, 3, 12, 13, 14, 26-р байруудын дунд болон гэр хорооллын 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт 18 м2 талбайд "Ухаалаг хогийн" савыг тус тус байршуулан ажиллаж байна. Ил харагдах хогийн савны газар дор 3 куб метрийн хэмжээтэй 2 том хогийн савыг байрлуулсан ба цаашид дүүргийн төвийн бүс болох 1-6 дугаар хороодын орон сууц, байшин хороолол дунд байрлуулахаар дүүргийн 2024 төсвийн тодотголд төсвийг суулган зураг төсвийн ажлыг гүйцэтгүүлэн Барилга хөгжлийн төвөөс магадлалын дүгнэлт авахаар хүсэлт илгээсэн. 2025 оны 01 дүгээр сард багтаан	100

						хуулийн дагуу тендерийн ажлыг зарлуулахаар төлөвлөсөн.	
АХ-2.5.10, НХТЖҮЧ-6.2.3, НЗДҮАХ-5.2.7 Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний давтамжийг нэмэгдүүлэх;							
8	Цэвэрлэгээ-ний давтамж	Тоо	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	6-9	12-20	Дүүргийн нийтийн эзэмшлийн 1230000 м2 талбайн арчилгаа, цэвэрлэгээг “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-ний зам талбайн инженер 4, мастер 7, зам талбайн үйлчлэгч 155, 1-6 дугаар хороодын бичил цэцэрлэгүүдийг 25 хүний бүрэлдэхүүнтэй зам талбайн үйлчлэгчид хариуцан ажилладаг бөгөөд ажилчдын цалин хөлсийг 2024 оны 03 дугаар сараас эхлэн 3,500,000 төгрөг болгон нэмэгдүүлснээр тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн иргэдийн бүлгийг өөрсдийн хөрөнгөөр тогтмол ажиллуулж 7-24 дүгээр хороод буюу 2, 3 дугаар бүсэд 33 хүний бүрэлдэхүүнтэй 2 бүлгийг тогтмол ажиллуулдаг. Дүүргийн гэр хорооллын 7-24 хороодод иргэдийн бүлэг 7 хоногт 2-3 удаагийн давтамжтайгаар түүвэр цэвэрлэгээг хийж, гэр хорооллын гуу жалга, далан сувгийн үүсмэл хог хаягдал болон халтиргаа гулгааг тогтмол цэвэрлэн ажиллаж байна.	100
Салбарын үр дүн: Орон сууцны хөтөлбөрийн хүрээнд орон сууцны хангамжийг 15 хувиар нэмэгдүүлнэ.							
ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙ							
НХТЖҮЧ 9.8.2, НЗДҮАХ 6.1.10 Нийтийн зориулалттай орон сууцуудын дээврийн засварын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;							
9	Дээвэр засварласан орон сууц	Тоо	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	49	40	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд 1-6, 15 дугаар хороодод 11 дээвэр, 3 фасадад хийх засварын ажлын тендер сонгон шалгаруулалтад “Интел хаитек” ХХК, “Буян нэмэх интер” ХХК-ны түншлэл шалгарч гэрээ хийн ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд 6 дугаар хороо, 26 дугаар	70

						байрны фасад засварыг “Эс эм би эм” ХХК хийж гүйцэтгэсэн. Мөн 2024 онд 1-6 дугаар хороодын 7 байрны дээвэр засварын ажлыг хийж гүйцэтгэхээр “Эко энерги ресурс ХХК шалгарч гэрээгээ байгуулсан. Зураг, төсвийн ажлын хүрээнд 1-р хороо, 3 байрны дээвэр, 3-р хороо, 1 байрны дээвэр, 5-р хороо, 3 байрны дээвэр засварын зураг, төсвийг "Гранд тех" ХХК хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгсөн. Мөн 2-р хороо, 4 байр, 6-р хороо, 10 байрны дээвэр засварын зураг, төсвийг "ММ архитектур" ХХК, 5-р хороо, 9 байр, 6-р хороо, 11 байрны фасад засварын зураг төсвийг "Тэмжин" ХХК, 1-р хороо, фасад засварын зураг төсвийг “Онч тэнхлэг” ХХК тус тус хийж гүйцэтгэж байна. 2, 3, 4-р хорооны 19 байрны фасад засварын зураг, төсвийн ажлын тендер сонгон шалгаруулалтыг зарлаад байна.	
НХТЖҮЧ-9.8.3 НЗДҮАХ-6.1.10 Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх;							
10	Шинэчилсэн цахилгаан шат	Тоо	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	24	15	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3-р хороо, 25/4, 17/2 дугаар байрнуудын лифтийг “Фүшили элеватор” ХХК хийж гүйцэтгэн Улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авсан. Дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 6 дугаар хороо, 28 дугаар байрны 2 дугаар орц, 72 дугаар байрны 2 дугаар орцны лифтний шаардлагатай эд анги, сэлбэг материалын техникийн тодорхойлолтыг дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлж тендер сонгон шалгаруулалтыг 9 удаа зохион байгуулахад оролцогч оролцоогүй тул дүүргийн төсвийн тодотголоор 6 дугаар хорооны 26, 28, 57, 58, 72 дугаар байрнуудыг лифтийг засварлахаар шийдвэрлэсэн. 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 26-р байрны лифт засварыг “Цамхаг констракшн” ХХК, 02 дугаар сарын 15-ны өдөр 57-р байрны лифт засварыг	70

						“Лифткон” ХХК, 02 дугаар сарын 26-ны өдөр 72-р байрны лифт засварыг “Минт хоупе элеватор” ХХК, 04 дүгээр сарын 10-ны өдөр 28 дугаар байрны лифт засварыг “Хан баян констракшн” ХХК, 12 дугаар сард 58-р байрны лифт засварыг “Лифткон” ХХК тус тус хийж ашиглалтад оруулсан. Мөн дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3, 4, 5, 6 дугаар хороодын 9 лифт засварын ажлыг хийж гүйцэтгэхээр 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 3/1121 тоот албан бичгээр “Улаанбаатар лифт” ОНӨТҮГ-аас техникийн тодорхойлолтыг авахаар хандсан бөгөөд уг тодорхойлолтын дагуу дүүргийн Худалдан авах ажиллагааны алба тендер сонгон шалгаруулалтыг зарласан.	
ЭРЧИМ ХҮЧ, МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО							
АХ- 4.2, НХТЖҮЧ 9.10.1, НЗДУБХЗҮАХ 6.3.29.1 Нийслэлийн гэр хорооллын болон зуслангийн бүсийн гэрэл цахилгаангүй, хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах, хүчдэлийн уналтыг сайжруулах төслийг үргэлжлүүлэх;							
11	Шинээр цахилгаанд холбох, хүчдэлийн уналтыг сайжруулах	Тоо	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	-	1,136	“Гэр хороодын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажил” төсөл арга хэмжээний хүрээнд дүүргийн 19, 23, 24 дүгээр хороодын 860 айл өрхийг найдвартай цахилгаан эрчим хүчинд холбох ажлыг зохион байгуулж, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ний Зуслангийн хэрэглэгчдэд үйлчлэх төвөөс дүүргийн 24 дүгээр хороо, Яргайт орчимд шинээр хийгдсэн 2 дэд өртөөг цахилгаан эрчим хүчинд холбож, 400 гаруй айл өрхийг найдвартай цахилгаан эрчим хүчээр хангасан. Мөн дүүргийн 20 дугаар хороо, Хувьсгалчдын Г-18 дугаар гудамжны 87 айл өрх нь цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр бетон шон /тулгуур/, тоолуурын нэгдсэн хайрцаггүйн улмаас цахилгаан	90

[illegible]

АХ-9.3.1, 9.3.12 НХТЖҮЧ- 9.19.1, 9.19.2 НЗДҮАХ-6.3.1.7 Явган хүний замыг шинээр барих;							
13	Шинээр барих явган хүний зам, урт	М2	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	-	70,000	Нийслэлээс 2024 оныг “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарласны хүрээнд дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4 байршилд тоглоомын талбай сэргээн засварласан. Мөн дүүргийн хэмжээнд 136 у/км явган зам байдаг бөгөөд орон нутгийн төсвийн 900.0 сая төгрөгөөр 15 байршил (1, 4, 6, 7, 10, 12, 16, 18, 20 дугаар хороо)-д 1500 м2 явган зам, 11 байршилд гудамж сайжруулах ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн бөгөөд гэр хорооллын болон орон сууц, нийтийн эзэмшлийн гудамж талбайд стандартад нийцсэн явган зам хийж гүйцэтгэх ажлын хүрээнд явган зам хийлгэх тухай нэгдсэн судалгааг нэгтгэн боловсруулж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн дэд бүтцийн газарт 2024 оны 04 дүгээр сард хүргүүлсний дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3000м2 явган замыг шинээр хийж гүйцэтгэсэн.	100
АХ-9.3.1, 9.3.12 НХТЖҮЧ- 9.19.1, 9.19.2 НЗДҮАХ-6.3.1.7 Дугуйн зам шинээр барих;							
14	Дугуйн зам, урт	Км	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	-	20	Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдэд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ “Унадаг дугуйн замын ажил” (Чингэлтэй дүүргийн Гэсэр сүмийн уулзвараас Анкарагийн гудамж хүртэлх 0.7 км дугуйн замын ажил) /Багц-2/-ын тендер сонгон шалгаруулалтад “Драгон бридж” ХХК шалгарч гэрээ байгуулсан боловч 2022 онд гэрээ нь цуцлагдаж ажил зогссон. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн Чингэлтэй дүүрэгт хэрэгжүүлэх “Унадаг дугуйн замын ажил”-ын төсөл арга хэмжээний тендер сонгон шалгаруулалтад “Драгон бридж” ХХК шалгарч Чингэлтэй дүүргийн Зурагтын уулзвараас	30

						Баянбүрдийн тойрог хүртэлх 0.6 км дугуйн замын ажлыг 2023 онд хийж гүйцэтгэсэн ба цаашид дугуйн замыг нэмж шинээр хийх, ашиглалтад оруулах байршил, нөхцөлийг судлан 2025 онд хийхээр бэлтгэл ажлыг хангаад байна.	
АХ-9.3.1,9.3.12, НХТЖҮЧ-9.19.1, 9.19.2, НЗДҮАХ-6.3.1.7 Дугуйн зогсоол шинээр барих;							
15	Дугуйн зогсоол	Тоо	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба	-	20	"Зуршлаас-Хэвшил рүү" аяны хүрээнд хөдөлгөөнт амьдралыг хэвшил болгохоор зорилт тавин "Бичил Глобус" санхүүгийн байгууллага нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн нутаг дэвсгэр Тусгаар тогтнолын талбай, 5-р сургууль, Соёл Урлагийн Их сургууль, дүүргийн эрүүл мэндийн төв, Өглөөний гудамж, Явуухулангийн цэцэрлэгт хүрээлэн, Баянбүрд орчим, 24-р сургууль, компьютер ланд төв зэрэг 9 байршилд "Унадаг дугуйн зогсоол" байршуулсан.	70
Үнэлгээний дундаж						88.7%	